

Ажиглалт судалгаа явуулах

Шинжлэх ухааны практикийн талаарх ойлголтоо гүнзгийруулэхэд нь сурагчдадаа туслаарай. Ажиглалт нь шинжлэх ухааны нэг суурь юм. Энэ дасгалуусгэсэн ажиглалт судалгааны чинь явцад таныг болон таны сурагчдыг хутлун чиглуулж тусална.

Зорилт:

- Экологийн ойлголтод ажиглалт судалгаа ямар ач холбогдолтойг сурагчид мэдэж авна
- Ажиглалт судалгааг тулувлуж, гуйцэтгэж, дун шинжилгээ хийх

Материал:

- Журнал эсвэл тэмдэглэлийн дэвтэр
- Секундомер эсвэл хором хэмжигч
- [Ажиглалт судалгааны баримтын хуудас](#)

Процесс:

- 1) Багш гурван төрлийн хяналт шинжилгээг (мониторинг) сурагчдад узуулж, ажиглалт судалгааны тухай танилцуулна
 - ▶ Эрдэм шинжилгээний тэмдэглэл хөтлөх
 - ▶ Хяналт/зураглал
 - ▶ Этограмм
- 2) Сурагчдаас асуу: Ажиглалт судалгааг ашиглан ямар төрлийн асуултуудад хариулж болох вэ?
- 3) Сурагчдыг дангаар нь эсвэл хосоор нь ажиллуулан, судалгааны амьтан сонгох, судалгааны асуулт тавих, ашиглах ажиглалтын аргаа тодорхойлохыг даалга.
 - ▶ Та нар амьтны хурээлэн, байгалийн цогцолборт газраар очиж, эсвэл ойр хавийнхаа амьтдыг ажиглаж болно. өөрөөр хэлбэл ажиглах боломжтой амьтнаа сонгоорой!
- 4) Сурагчид секундомерээ ашиглан цагаа хянаж, судалгааны амьтнаа 15 минут ажиглана.

5) Ангидаа эргэн ирж, өгөгдөлдөө дүн шинжилгээ хийх 20-30 минутыг сурагчдад олго.

▶ Сурагчид өгөгдлийг ашиглан судалгааны асуултдаа хариулахыг оролдох ёстой.

○ Хэрэв ингэж чадахгүй байвал судалгааны аргачлалын сонголт нь зөв байсан эсэхийг сурагчид тодорхойлох ёстой.

▶ Таны судалгааны амьтны илүү том популяцийн талаар ерөнхий дүгнэлт гаргах боломжтой юу?

▶ Үр дүнг сайжруулах эсвэл илүү их мэдээлэл олж авахын тулд ямар нэг юмыг өөрөөр хийх боломжтой юу?

▶ Цаашид судалгааны мөрөөр ямар асуултуудыг судалж болох вэ?

6) Бүлэг тус бүр эсвэл сурагч бүрд судалгаа болон үр дүнгээ ангидаа танилцуулахад 1-2 минут өг.

 WCS presents

FIELD SIGHT

"WCS Education" болон манай байгалийн
цогцолборт газрын хөтөлбөрийн талаар
мэдээлэлт олж авахыг хүсвэл
wcs.org/education хаягаар орж үзнэ үү

 @WCSEducation

 @WCSEducation